



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/6/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734

Цахим хаяг: dornogovi@audit.com

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020

Цахим хаяг:

Аудитор:

М.Бямбадорж

Утас: 99031981

Цахим хаяг: mnbaidithhk@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....*	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	Error! Bookmark not defined.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Орон нутгийн өмчийн III байр,

Утас: (705) 2-27-34

2019.02.27 № 1-6/288

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
О.ОДОНЧИМЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

О.ОДОНЧИМЭГ
ЗАХИРАЛ

Аудитын гол асуудал:

- 2018 онд тус сургуулийн нь Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд хоол хүнс 21534.9 мянган төгрөг төсөвт өртөг бүхий бараа худалдан авах үйл ажиллагааг сургуулийн захиралын 2018/08/29-ны өдрийн А/30 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулагдаж 2018/08/30-нд сонгон шалгаруулалт хийх тов гарсан байна. Уг тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, протокол байхгүй, боловсруулсан тендерийн баримт бичиг байхгүй, сонгон шалгаруулалт хийсэн үнэлгээний хуудас болон бусад тэмдэглэл байхгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ хуулийг мөрдөн ажиллаагүйг илтгэж байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хууль 41.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8.-д "Тухайн байгууллага журмын 7.5-д заасан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэх баримтын эх хувь, хяналтын хуудасны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад: урсгал зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд төсвийн захирагчийн тушаал, төсвийн задаргааг баталсан хавсралт, товчоо, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримт, өр төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт, жижиг мөнгөн сангийн тайлан, банк дахь бэлэн мөнгөний дансны хуулга, хөрөнгийн зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн дансны хуулга болон бусад бичиг баримт хамаарна. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна" заасан заалтыг тус тус зөрчсөн байна.


Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал О.Одончимэг-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 01 дугаар сарын 31-наас 2018 оны 02 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт "Мөнгө Нөөц Баялаг аудит" ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Мөнгө Нөөц Баялаг аудит" ХХК -д 2018 оны 01 дугаар сарын 31-ны өдрийн 13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургууль нь Сургалтын чанарыг эрхэмлэсэн, оюуны чадавхаа хөгжүүлсэн, дэгийг баримтлагч хүүхдийг төдөвшүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Боловсролын тухай хуулиар Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх,

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургууль удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

байхгүй

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acoulous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлого* -ын 1 хувиар сонгов.

Нийт орлого -г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Тус байгууллага нь төсвийн санхүүжилтээр төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг учраас төрөөс олгож байгаа санхүүжилтийн орлогыг суурь үзүүлэлт болгон сонгон авлаа - холбоотой юм.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны Нийт зарлага 1,341,676.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 13,416.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь нийт зарлагын 1 хувиас хэтэрсэн алдаа, зөрчил нь санхүүгийн тайланд нөлөөлөхүйц алдаа болох юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	1,284.80	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	21,534.9	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	22,819.7	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Тайлант онд Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд хоол хүнс 21534.9 мянган төгрөг төсөвт өртөг бүхий бараа сургуулийн захиралын 2018/08/29-ны өдрийн А/30 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулагдаж 2018/08/30-нд сонгон шалгаруулалт хийх тов гарсан байна. ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөн ажиллаагүй байна.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

- Цалингийн тооцоолол, бүртгэл, хяналт, Багш нарын үр дүнгийн урамшуулалын үнэлгээ, тооцоолол,

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 967213.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 961673.6 мянган төгрөг буюу 99,94 хувьтай байгаа нь Цалин хөлс, ажил олгогчийн НДШ нийт 2933,1 мянган төгрөгийн хэмнэлт гарсан нь төсвийн хэмнэлтэд голлон шалтгаалжээ.

Өөрийн орлогын төлөвлөгөө 1036,5 мянган төгрөг тавигдаж бүрэн биелсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Сар бүрийн цалингийн хүснэгт болон харилцахын хуулга, ерөнхий журналаар 975.0 төгрөгийн хууль бус суутгал, ажиллагсадын орон тооны зөрүүтэй байдал илэрсэн.

Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна БСШУССайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаал тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Төсвийн төлөвлөлтийг боловсруулахдаа БСШУССайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаалыг мөрдөн ажиллаж ажиллагсадын орон тоо бүтцийг мөрдөн ажиллах шаардлагатай. Хөдөлмөрийн хуулийн 63 дугаар зүйл, Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал О.Одончимэг, нягтлан бодогч Б.Мөнх-Оюун

Эрсдэл

1. Цалингийн зардал хэтэрч төсвийн үр ашиггүй зардал бий болох.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Авлага өглөгийн өсөлт бууралт, ахнан шатны баримт, санхүүгийн тайлангийн илэрхийлэлийг тулган шалгахад 309.8 мянган төгрөгийг НДХ-д илүү шилжүүлсэн байна.

Энэ нь эрх ба үүрэг, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Төсвийн хуулийн мөрдөн ажиллаж авлага өглөг үүсгэхгүйн тулд төсвийн хуваарилалт, төлөвлөлтийг оновчтой болгох, үүссэн өр төлбөрийг шийдвэрлэхийн тулд холбогдох тооцооллыг бодитой хийх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал О.Одончимэг, нягтлан бодогч Б.Мөнх-Оюун

Эрсдэл

Төсвийг үр ашиггүй, бодит тооцоололгүй зарцуулж төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэхгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зерчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.АРИУНАА

Огноо: *1/6/23*

Ц.ЛҮНДЭГМАА

Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.Бямбадорж

М.БЯМБАДОРЖ

Огноо:

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 АУДИТАЛСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	127,418,754.01	115,081,910.32
33	АВЛАГА	29,232,400.00	309,762.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,533,060.00	00.00
335	Бусад авлага	27,699,340.00	309,762.00
3351	Байгууллагаас авах авлага	27,699,340.00	309,762.00
35	БАРАА МАТЕРИАЛ	98,186,354.01	114,772,148.32
351	Түүхий эд материал	6,394,705.90	6,366,713.92
35110	Тусгай зориулалттай материал	6,113,946.90	6,053,764.92
35130	Эм боох материал	280,759.00	312,949.00
354	Хангамжийн материал	91,791,648.11	108,405,434.40
35410	Бичиг хэргийн материал	1,282,550.00	759,840.00
35420	Аж ахуйн материал	3,409,923.00	3,956,723.00
35440	Тулш, шатах тослох материал	86,910.00	495,000.00
35450	Барилгын засварын материал	584,930.00	1,079,610.00
35460	Хүнсний материал	7,228,152.50	7,537,087.50
35470	Бусад хангамжийн материал	79,199,182.61	94,577,173.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,769,535,047.56	2,738,576,777.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,769,535,047.56	2,738,576,777.50
392	Биет хөрөнгө	2,769,507,547.68	2,693,176,777.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,380,995,226.00	2,461,891,899.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-821,101,372.24	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	172,410,309.46	185,385,291.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,722,503.81	-125,466,542.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	132,688,232.06	105,871,139.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-54,760,777.05	-38,790,489.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	68,097,100.00	62,136,314.88
39215	Хуримтлагдсан элэгдэл	-55,128,892.85	-296,666.38
39217	Ном	40,030,226.11	42,445,830.37
393	Биет бус хөрөнгө	27,499.88	45,400,000.00
39301	Програм хангамж	1,110,000.00	510,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,082,500.12	-510,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	45,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	2,896,953,801.57	2,853,658,687.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,577,800.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,577,800.00	00.00
413	Өглөг	3,577,800.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,893,376,001.57	2,853,658,687.82
51	Засгийн газрын хувь оролцоо	2,893,376,001.57	2,853,658,687.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	483,032,534.16	528,838,633.66
51101	Өмч: - төрийн	483,032,534.16	528,838,633.66
512	Хуримтлагдсан үр дүн	1,778,342,923.79	1,774,875,958.68
51210	Өмнөх үеийн үр дүн	1,778,342,923.79	1,914,200,814.15
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	139,324,855.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	632,000,543.62	349,944,095.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	2,896,953,801.57	2,853,658,687.82

4417144353
EHOA0056 902570

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Омнох оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,035,818,652.86	1,202,351,300.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,315,852.86	227,950,000.26
120	Нийтлэг татварын бус орлого	58,315,852.86	227,950,000.26
120004	Тосов байгууллагын өөрийн орлого	58,315,852.86	227,950,000.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,396,725.00	3,115,450.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	27,919,127.86	224,834,550.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,146,000.00	8,224,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих	970,356,800.00	966,176,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,146,000.00	8,224,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,146,000.00	8,224,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,072,605,957.41	1,066,369,396.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,072,605,957.41	1,066,369,396.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	931,466,006.41	999,627,411.54
2101	Цалин хөлө болон нэмэгдэл урамшил	486,289,963.00	532,534,095.00
210101	Үйлсэн цалин	271,173,421.00	295,921,714.00
210102	Нэмэгдэл	170,108,400.00	173,799,205.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,634,500.00	17,683,630.00
210104	Урамшуулал	29,373,642.00	45,129,546.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлхө шимтгэл	55,669,098.00	64,448,670.00
210201	Тэтгэврийн даатгал	36,518,159.00	43,263,176.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,775,957.00	5,313,590.00
210203	УОМЦО-ний даатгал	3,950,475.00	4,250,854.00
210204	Ажилгүйдлийн даатгал	947,681.00	1,056,457.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,476,826.00	10,564,593.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	213,153,439.00	215,809,611.00
210301	Гэрэл, цахилгаан	7,661,335.00	9,011,266.00
210302	Түлш, халаалт	193,365,090.00	193,391,210.00
210303	Цэвэр, бохир ус	12,127,014.00	13,407,135.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,507,153.16	13,028,846.69
210401	Бичиг хэрэг	2,040,577.00	2,021,010.00
210402	Тээвэр, шатахуун	1,132,505.00	749,590.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,680,640.00	1,634,873.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	1,392,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,473,431.16	7,230,873.69
2105	Нормативт зардал	27,084,460.50	24,572,695.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	374,240.00	423,610.00
210502	Хоол, хүнс	22,314,987.50	21,224,825.00
210503	Нормын хувцас, зоолон эдгэл	4,395,233.00	2,924,260.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,610,666.00	43,645,256.00
210604	Урсгал засвар	28,610,666.00	43,645,256.00
2107	Томилдолт, зочны зардал	646,400.00	534,600.00
210702	Дотоод албан томилдолт	646,400.00	534,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,199,756.00	3,159,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,199,756.00	3,159,560.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,305,070.75	101,894,077.85

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	345,800.00	1,333,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	1,481,000.00	3,262,500.00
210903	Үндсэн хөрөнгийн эзэгдэл, хоргодол	98,478,270.75	97,297,777.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,139,951.00	66,741,985.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	138,167,817.00	61,202,342.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,690,800.00	29,628,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	59,192,000.00	18,919,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,140,142.00	11,171,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,144,875.00	1,482,542.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,972,134.00	5,539,643.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-36,787,304.55	135,981,903.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,188,053.90	275,306,759.19
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	3,188,053.90	3,708,743.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	271,598,015.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-39,975,358.45	-119,324,855.47



Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	617,765,300.00	1,005,045,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,716,700.00	3,115,450.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,716,700.00	3,115,450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,716,700.00	3,115,450.00
1200042	Туулах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,716,700.00	3,115,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	616,048,600.00	1,001,930,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	27,529,000.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	27,529,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	614,848,600.00	966,176,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,200,000.00	8,224,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,200,000.00	8,224,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	513,573,904.00	973,775,892.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	513,573,904.00	973,775,892.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,210,962.00	907,033,907.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,889,639.00	532,542,807.00
210101	Үндсэн цалин	137,851,593.00	295,930,425.00
210102	Нэмэгдэл	130,953,137.00	173,799,205.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	17,683,630.00
210104	Урамшуулал	15,084,909.00	45,129,547.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,754,523.00	66,624,120.00
210201	Тэтгэврийн даатгал	20,363,802.00	45,482,120.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,815,851.00	5,272,258.00
210203	ҮОМШО-ний даатгал	2,382,391.00	4,236,642.00
210204	Ажилгүйдлийн даатгал	562,951.00	1,057,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,629,528.00	10,575,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмал зардал	121,539,420.00	216,217,701.00
210301	Гэрэл, цахилгаан	4,298,663.00	9,011,266.00
210302	Түлш, халаалт	110,303,600.00	193,799,300.00
210303	Цэвэр, бохир ус	6,937,157.00	13,407,135.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,656,883.00	13,592,663.00
210401	Бичиг хэрэг	175,800.00	1,140,000.00
210402	Тээвэр, шатахуун	674,030.00	748,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	833,243.00	1,634,873.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	1,392,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	873,810.00	8,676,600.00
2105	Нормативт зардал	8,880,121.00	23,501,320.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	470,800.00
210502	Хоол, хүнс	8,880,121.00	21,533,760.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,496,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	43,644,936.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	488,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	43,156,936.00
2107	Томиллолт, зочны зардал	356,400.00	534,600.00
210702	Дотоод албан томиллолт	356,400.00	534,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	794,976.00	4,901,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	794,976.00	4,901,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,039,000.00	5,473,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,333,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	2,039,000.00	4,140,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,362,942.00	66,741,985.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,362,942.00	61,202,342.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,009,200.00	29,628,600.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,052,000.00	18,919,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,301,742.00	11,171,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,482,542.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,539,643.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,539,643.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	104,191,396.00	31,269,858.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	31,269,858.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	31,269,858.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	31,269,858.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	31,269,858.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-31,269,858.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	104,191,396.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	104,191,396.00	00.00

4417144353
 EHOA0056 9025707

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцоотой нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,032,534.16	632,429,429.74	1,817,889,396.12	2,933,351,360.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	428,886.12	428,886.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,032,534.16	632,429,429.74	1,818,318,282.24	2,933,780,246.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(428,886.12)	-	(428,886.12)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(39,975,358.45)	(39,975,358.45)
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,032,534.16	632,000,543.62	1,778,342,923.79	2,893,376,001.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	135,857,890.36	135,857,890.36
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,032,534.16	632,000,543.62	1,914,200,814.15	3,029,233,891.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(82,056,448.14)	-	(82,056,448.14)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүдэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	45,806,099.50	-	(139,324,855.47)	(93,518,755.97)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	528,838,633.66	549,944,095.48	1,774,875,958.68	2,853,658,687.82

Аудитлагч
 4417144353
 ЕЮА0056 9025707

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 АУДИТАЛСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЭЗЭЛИЙН ДҮН	967,213,260.00	961,673,607.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	967,213,250.00	961,673,607.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	905,475,000.00	901,953,807.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	529,071,400.00	526,542,807.00
210101	Үндсэн цалин	291,179,100.00	289,930,425.00
210102	Нэмэгдэл	174,570,300.00	173,799,205.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,700,000.00	17,683,630.00
210104	Урамшуулал	45,622,000.00	45,129,547.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,268,100.00	65,863,620.00
210201	Тэтгэврийн даатгал	45,117,300.00	44,721,620.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,287,600.00	5,272,258.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,230,100.00	4,236,642.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,057,600.00	1,057,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,575,500.00	10,575,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,244,100.00	216,217,701.00
210301	Гэрэл, цахилгаан	8,493,900.00	9,011,266.00
210302	Түлш, халаалт	193,822,200.00	193,799,300.00
210303	Цэвэр, бохир ус	13,928,000.00	13,407,135.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,981,100.00	15,844,663.00
210401	Бичиг хэрэг	1,140,000.00	1,140,000.00
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	748,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,000.00	1,634,873.00
210404	Ном, хэвлэл	195,500.00	125,000.00
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,392,000.00	1,392,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,803,600.00	10,803,600.00
2105	Нормативт зардал	23,505,700.00	23,501,320.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	470,800.00	470,800.00
210502	Хоол, хүнс	21,534,900.00	21,533,760.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,496,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,193,500.00	47,193,336.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,036,400.00	4,036,400.00
210604	Урсгал засвар	43,157,100.00	43,156,936.00
2107	Томилалт, зочны зардал	535,200.00	534,600.00
210702	Дотоод албан томилалт	535,200.00	534,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	781,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	781,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	547,590.00	547,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,333,800.00	1,333,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,142,100.00	4,140,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,738,200.00	59,719,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,738,200.00	59,719,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,647,000.00	29,628,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,919,800.00	18,919,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,171,400.00	11,171,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	967,213,250.00	967,213,250.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	966,176,800.00	966,176,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээ санхүүжих	966,176,800.00	966,176,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,036,450.00	1,036,450.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,036,450.00	1,036,450.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	59	58
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	38	38
620003	Үйлчлэх ажилтан	20	19

441714435
E-040056 902570